



# Төлбөрийн хэрэгсэл

## БЭЛЭН МӨНГӨ

Бэлэн мөнгөөр хийх төлбөр нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хийгдэж буй жижиглэнгийн худалдаа, үйлчилгээний төлбөр тооцоонд хэрэглэгдэж байгаа үндсэн хэрэгсэл юм. Монголбанкаас бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлж, бэлэн бус төлбөр тооцоо давамгайлсан нийгмийг бүрдүүлэх үндсэн зорилгыг тодорхойлж, бэлэн мөнгөний өргөн хэрэглээг хязгаарлахыг зорьж байна.



## Кредит шилжүүлэг

Банкны харилцагч төлбөр тооцоогоо гүйцэтгэхийн тулд төлбөрийн даалгаврын цахим эсхүл цаасан хэлбэрийг сонгож үйлчлүүлэх боломжтой. Банк хоорондын төлбөр тооцооны системд төлбөрийн даалгаврын цахим хэлбэрийг ашигладаг бөгөөд банкууд нь төлбөрийн даалгаврыг үндэслэн гүйлгээ үүсгэн дамжуулдаг.

## Дебит шилжүүлэг

Монгол Улсын төлбөр тооцооны системд банк хооронд дебит шилжүүлэг харьцангуй бага хэмжээгээр хийгддэг. Энэ нь банк дотроо буюу тухайн харилцагч болон төлбөр хүлээн авагч байгууллагын данс нэг банкинд байршиж байх тохиолдолд хийгддэг бөгөөд харилцагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр орон сууцны төлбөр, суурин утас, интернетийн төлбөр зэргийг дебит шилжүүлгээр хийдэг.

## Төлбөрийн карт



Манай улсын томоохон банкуудын нэг болох Голомт банк нь 1999 онд "Mastercard international" байгууллагын гишүүн болж Мастеркартыг гаргаснаар олон улсын төлбөрийн картын сүлжээнд холбогдсон. Ингэснээр бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох төлбөрийн картын үйлчилгээ Монгол Улсад анх нэвтэрсэн юм. Одоогийн байдлаар 12 банк энэхүү үйлчилгээг үзүүлж байна. Эдгээрээс ХААН банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Төрийн банк, Хас банк, Капитал банк төлбөрийн картын нэгдсэн сүлжээнд шууд холбогдож, бусад банкууд дэд гишүүнээр холбогдож карт эзэмшигчдийн төлбөр тооцоог гүйцэтгэж байна.

Банкуудын гаргасан төлбөрийн картын тоо жилээс жилд өсөж, 2016 оны эцсийн байдлаар 4.0 саяд хүрснээс 1.5 сая карт нь идэвхтэй ашиглагдаж байна. Мөн үеийн байдлаар төлбөрийн карт хүлээн авагч төхөөрөмжөөр нийт 12.5 их наяд төгрөгийн 151.1 сая ширхэг гүйлгээ хийгдсэн байна. Монгол Улсад зайн, чип болон соронзон тууз бүхий картууд төлбөр тооцоонд ашиглагдаж байна.

Монголбанкаас авсан зөвшөөрлийн үндсэн дээр банкууд "VISA", "Mastercard", "UnionPay", "AMEX", "JCB", "Т карт" гэсэн 5 төрлийн картыг өөрийн банкны нэрийн өмнөөс гаргаж байна.

Монголбанк нь Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийг бэлэгдэн нэргээсэн үндэсний брэнд "Т карт"-ыг банкуудтай хамтран гаргах ажлыг амжилттай зохион байгуулж, 2012 онд нийтийн хүртээл болгосноор 2016 оны эцсийн байдлаар 2.7 сая ширхэгт хүрээд байна.

Тус картыг гаргаснаар иргэдийн цалин, тэтгэвэр, халамжийн мөнгө, хүүхдийн мөнгө зэрэг төрөөс иргэдэд олгож буй бусад тэтгэмжийг энэхүү төлбөрийн картаар, бэлэн бус хэлбэрээр олгох нь төрийн үйлчилгээ иргэдэд шуурхай хүрч эхлэх юм.

## Хөдөлгөөнт банкны үйлчилгээ

Монгол улсад бэлэн бус төлбөр тооцоо нэмэгдэхийн сацуу шинэ технологи дээр суурилсан төлбөрийн хэрэгслүүд бий болж байгаагийн нэг нь хөдөлгөөнт банкны үйлчилгээ билээ.

Монголбанкаас эдгээр хэрэгслүүдийг нэгдсэн, нээлттэй бодлогын хүрээнд дэмжих зорилгоор 2012 онд "Хөдөлгөөнт банкны үйлчилгээ, цахим мөнгөний талаар баримтлах бодлого, 2014 онд Хөдөлгөөнт банкны журмыг тус тус батлан гаргасан. Эдгээр эрх зүйн баримт бичиг батлагдаж хөдөлгөөнт банкны тухай нэгдсэн ойлголтыг бий болгож, үйл ажиллагааны нууцлал, аюулгүй, найдвартай байдлыг хангах, эрсдэлийг хэрхэн удирдах болон хариуцлагын тогтолцоог бий болгосноор харилцагчдын банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлээд зогсохгүй газар зүйн байршил, цаг хугацаанаас үл хамааран банкны үйлчилгээг түргэн шуурхай, хялбар хургэх боломжийг нэмэгдүүлж, бэлэн бус төлбөр тооцоо, хөдөлгөөнт банкны үйлчилгээний хөгжлийг цаашид дэмжих юм.



## Мобайл банкны үйлчилгээ

Алслагдсан хөдөө орон нутгийн иргэдэд банкны үйлчилгээг хүргэх зорилгоор банкууд мобайл банкны үйлчилгээг нэвтрүүлж эхэлсэн. Энэ үйлчилгээ нь харилцагч банкинд байгаа өөрийн нэрийн данс руу гар утас ашиглан алсаас хандаж гүйлгээ хийх үйлчилгээ юм. Мобайл банкны үйлчилгээг 2016 оны эцсийн байдлаар 2.7 сая хэрэглэгч төлбөр тооцоонд ашиглаж байгаагас 1.3 сая нь уг үйлчилгээг идэвхтэй ашиглаж байна. Нийт мобайл банк хэрэглэгчийн 45.4 хувь буюу 1.2 сая хэрэглэгч орон нутагт байна.

Энэхүү үйлчилгээний давуу тал нь аль ч үүрэн холбооны операторын хэрэглэгч худалдан авсан бараа, үйлчилгээнийхээ төлбөрийг гар утсаа ашиглан төлөхөөс гадна дансандaa мөнгө хийх, данснаасаа бэлэн мөнгө аваадаа банкны салбарт очилгүйгээр, банкны салбар хаасан хойно ч үйлчилгээ үзүүлэгч банкны гэрээт төлөөлөгчөөр дамжуулан гүйлгээгээ хийх боломжтой. 2016 оны байдлаар нийт 1343 гэрээт төлөөлөгч мобайл банкны үйлчилгээг түгээн, ажиллаж байна.

## Интернэт банкны үйлчилгээ

Интернэт банкны үйлчилгээг 2002 оноос банкууд нэвтрүүлж, одоогийн байдлаар 11 банк энэхүү үйлчилгээг үзүүлж байна. Интернэт протокол ашиглан хөдөлгөөнт банкны үйлчилгээ авахыг интернэт хандалт гэж тодорхойлж байна. 2016 оны байдлаар улсын хэмжээнд нийт 1.1 сая интернэт банкны хэрэглэгч байгаагас 473.3 мянга нь сард 3 ба түүнээс дээш удаа гүйлгээ хийн уг үйлчилгээг идэвхтэй ашиглаж байна.

Энэ үйлчилгээ нь интернэтээр дамжуулан банкинд байгаа өөрийн нэрийн дансаар олон улс болон банк хооронд, өөрийн данс хооронд мөнгө шилжүүлэх, төлбөр төлөх, үлдэгдэл шалгах зэрэгээр санхүүгийн болон санхүүгийн бус гүйлгээг хийх боломжийг харилцагчид олгодог давуу талтай.

Монголбанкаас улирал бүр боловсруулдаг Хөдөлгөөнт банкны тайлангаас үзвэл орон нутагт мобайл банкны хэрэглээ, хот суурин газарт интернэт банкны хэрэглээ зонхицж байна.